

ЗАХИРЛЫН МЭДЭЭЛЭЛ

Сайн байцгаана уу,

Багш сурагчид маань амралтаа дуусгаад хичээлдээ буцаж оронд бид баяртай байна. Та бүхэн сайхан амарсан гэдэгт би итгэлтэй байна. Багш нар маань сурагчдаа шалгалтанд нь бэлтгээд завгүй байна. 1-р семестр 1 сарын сүүлчээр дуусна.

Өвлийн энэ сарууд бол шинээр багш нарыг сонгон шалгаруулж авдаг улирал. Энэ жил дөрвөн багш манай сургуулиас буцна. Сургуулийн Удирдах Зөвлөл манай сурагчдад хамгийн шилдэг тэргүүний чанартай боловсрол олгохыг зорьдог. Нэг ангид ногдох сурагчдын тоог цөөлж, сурагчдад чанартай ИВ хөтөлбөрийг эзэмшүүлэхийн тулд хангалттай тооны өндөр ур чадвартай сайн мэргэшсэн багш нарыг сонгон шалгаруулж авахыг Удирдах Зөвлөлөөс надад даалгасан юм.

Ирэх хичээлийн жилд ажиллах багш нарыг шалгаруулж авахаар би амралтын үеэрээ багш нарыг сонгон шалгаруулж авах хэд хэдэн хуралд оролцоод ирлээ. Би энэ үеэрээ долоон багш шинээр ажилд авсан.

Захирал Greg Rayl

ХУАНЛИД ТЭМДЭГЛЭХ ӨДРҮҮД:

- 1 сарын 26 ЭБХ-ны хурал 15 цагаас номын санд болно
- 2 сарын 1 2-р семестр эхэлнэ
- 2-р улирлын дугуйлангууд хичээллэж дууссан
- 2 сарын 2 3-р улирлын дугуйлангууд хичээллэж эхэлнэ

ДУНД СУРГУУЛИЙН МЭДЭЭ

Та бүхэнд шинэ оны мэнд дэвшүүлье. Сургуульдаа тавтай морилно уу. Та бүхэн амралтаа сайхан өнгөрүүлсэн гэдэгт би итгэлтэй байна. Сурагчид маань амралтаа дуусгаад сургуульдаа буцаж ирж хичээлийн жилийг амжилттай дуусгахаар үргэлжлүүлэн суралцаж байна.

Цаг агаар эрс хүйтэрч байгааг та бүхэн бүгд мэдэж байгаа. Гэсэн хэдий ч сурагчид маань хичээлдээ малгай, бээлийгүй дулаан хувцаслаж ирэхгүй байгаад би санаа зовж байна. Хүйтний эрч чангарч эрс хүйтрэх нь аюултай тул бид та бүхний аюулгүй байдалд анхаарал тавих ёстой. Замын хөдөлгөөн зогсож та бүхэн явган явах ч юм уу эс бөгөөс гэнэтийн байдлаас болоод машинаасаа буух тохиолдол гарахыг хэн ч мэдэхгүй. Тиймээс та бүхэн хичээлдээ дулаан хувцаслаж ирэх хэрэгтэй.

2-р улирал энэ сарын сүүлээр дуусна. Ахлах ангийн сурагчид шалгалтандаа бэлтгэж эхлээд байна. Дунд ангийн сурагчдын хичээл шалгалтын үеэр үргэлжлэн орох бөгөөд ахлах ангийнхан шалгалт өгч байх үеэр та бүхэн аль болох чимээ шуугиан гаргахгүй байхыг анхааруулж байна.

Кристин баярын өмнө Fraternite de Notre Dame асрамжийн 23 хүүхдэд бэлэг өгсөн мөн Солонго төвийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд тусалсан бүх багш сурагчид, эцэг эхчүүддээ баярлалаа. Манай сурагчид тэдэнд бэлэг өгөхөөс гадна бас хоол хүнсний хандив цуглуулж өгсөн. Асрамжийн хүүхдүүд та бүхний бэлгийг хүлээн авч их баяртай байсан. Тэдэнд тусалсан сурагчдаараа би бахархаж байна. Бусдад туслах Сайн Үйлсийн Хандиваа та бүхэн үргэлжлүүлнэ гэдэгт би итгэлтэй байна.

Сурагчидгүйгээр сургууль бол зүгээр л нэг хоосон барилга байдаг. Та бүхэнтэй амралтын дараа дахин уулзсандаа баяртай байна. Та бүхэн хүүхдийнхээ сургалтын талаар ярилцахыг хүсэж байвал дуртай цагтаа бидэнтэй холбоо барьж уулзах цаг аваарай.

**Дунд Сургуулийн Эрхлэгч
Betsy Hanselmann**

БАГА СУРГУУЛИЙН МЭДЭЭ

Та бүхэн өвлийн амралтаа сайхан өнгөрүүлсэн гэдэгт би итгэлтэй байна. Сургуульдаа тавтай морилно уу. 1-р семестр дуусахад хоёр долоо хоногийн хичээл үлдлээ. 1-р семестрийн дүн 2 сарын 5-нд гарна.

Эрүүл Ахуй, Ариун Цэврийн талаар: Хэдийгээр H1N1 вирусын тархалт намдсан ч бид үргэлжлүүлэн ханиаж найтаахдаа амаа таглаж гараа тогтмол угааж ариун цэврийг сайтар сахих болно. Та бүхэн хүүхдүүддээ ариун цэвэр сайн сахих талаар анхааруулж хэрвээ хүүхдэд тань ханиадны шинж тэмдэг илэрвэл хичээлд нь явуулалгүй гэрт нь байлгаарай.

Цаг агаарын эрс хүйтрэл: Сурагчид гадаа гаралгүй дотор тоглож байгаа. Гэхдээ бид хүйтний эрч суларвал сурагчдыг гадаа гаргах болно. Иймээс сурагчид хичээлдээ малгай, ороолт, бээлийтэй дулаан хувцаслаж ирж байх хэрэгтэй.

Хичээл тарахад сурагчдыг авах талаар: Хэрвээ хүүхдийг тань өөр жолооч, асрагч авах буюу хүүхэд тань найзынхаа унаанд дайгдаж явах бол та бүхэн ангийн багшид нь буюу сургуулийн ресепшинд заавал бичгээр мэдэгдэж байх шаардлагатай.

Хүсэлт: Хэрвээ та бүхэнд хүүхдэд тань багадсан хэрэглэхгүй байгаа бэлтгэлийн өмднүүд байгаа бол бидэнд өгөөрэй. Зарим тохиолдолд бага ангийханы өмдийг солих хэрэгцээ гарах үед бид хэрэглэх болно. Зургийн тэнхимд та бүхэн хуучин сонин сэтгүүл, пластик сав, картонон хайрцаг, хөөсөнцөр тавагнууд, цилиндр савнууд зэрэг зүйлсийг хандивлаарай. Зургийн багш нар та бүхний хандивыг дуртайяа хүлээн авах болно.

Бага Сургуулийн Сурагчдын Жүжигчилсэн Тоглолт: “Charlie and the Chocolate Factory” жүжгийг бага ангийн сурагчид 3 сарын 18-ны Пүрэв гарагт тоглох болсоныг та бүхэнд баяртайгаар уламжилъя. Та бүхэн энэ орой хүрэлцэн ирж бидний тоглолтыг сонирхоорой.

Бага Сургуулийн Эрхлэгч Jan Wiggins

СУРАГЧДЫН ЗӨВЛӨЛӨӨС

Олон Улсын Хатагтай нарын Нийгэмлэгт хандивлахаар амралтаараа ариун цэврийн жижиг бүтээгдэхүүн цуглуулж ирсэн эцэг эхчүүд, сурагчиддаа баярлалаа. Бид олон газраас сайн бүтээгдэхүүнүүд цуглуулж чадлаа. Хэрвээ та бүхэнд нэмж хандивлах зүйлс байгаа бол ирэх долоо хоногийн эхээр авчирч өгнө үү. Цуглуулсан хандивыг Олон Улсын Хатагтай нарын Нийгэмлэгийн гишүүн ирэх долоо хоногийн сүүлээр хүлээж авах болно.